

АГУУЛГА

ОРШИЛ	3
НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ	4
1.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага	4
1.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд	5
ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
2.1 Төслийн товч танилцуулга	8
2.2 Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал	10
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	12
3.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл	12
ДӨРӨВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	14
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	20
4.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	22
4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	22
4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	34
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал.....	37
ДҮГНЭЛТ	38

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ГАРЧГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нөлөөллийн эрчим.....	12
Зураг 1.Төслийн талбайн сансрын зураг	8

ОРШИЛ

“Цагаан-Овоот уул” нэртэй MV-021083 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1740 км, аймгийн төв Өлгий хотоос баруун зүгт 55-60 км, Цэнгэл сумын төвөөс зүүн хойш 10-15 км зайд тус тус оршдог.

Уг талбайн баруун хойд болон зүүн хэсэгт алтны илрэлд тулгуурлан 2017 онд хувийн хөрөнгөөр нарийвчилсан хайгуулын ажил хийлгэж 2018 оны 4-р сарын 5 өдөр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн 2018 оны 04-р сарын 05-ний ХХ-03-09 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2018 оны 5-р сарын 11-ны өдрийн н/25 тоот тушаалаар MV-021083 тоот тусгай зөвшөөрөл бүхий Цагаан-Овоот уул алтны үндсэн ордын бодитой (В) зэрэглэлийн хүдрийн нөөц 75534.87 тн, алт 764.22 кг, боломжтой (С) зэрэглэлийн хүдрийн нөөц 19198.79 тн, алт 260.52 кг, нийт (В+С) хүдрийн нөөц 94733.66 тн, алт 1024.74 кг-аар Улсын нэгдсэн нөөцийн бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн байна. Алтны хүдрийн биет нь дунджаар 10.1 г/тн алтны агуулгатай, 1.6 метр дундаж зузаантай, баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон, 70 градусын уналын өнцөг бүхий судал хэлбэртэй юм. Судал хэлбэртэй хүдрийн биетийн суналын дагуу 300 метр уртад хайгуул явуулж 100 метр хүртэл гүнд өрөмдлөгөөр тогтоож, нөөц тооцоолсон, цаашид нөөц өсөх бүрэн боломжтой юм. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хувьд мөн шинээр хүдрийн биет илрэх боломжтой, хэтийн төлөв сайтай орд юм. “Эс Жи групп” ХХК нь “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг түшиглэн уурхай, үйлдвэр байгуулж орон нутгийн нийгэм, эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулсан компани болохоор зорин ажиллаж байна.

Алтны үндсэн ордыг ашиглах энэхүү төсөл хэрэгжсэнээр нийгэм эдийн засгийн орчинд орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, 186 хүний ажлын байр шинээр бий болох, ажилчдын 50-аас доошгүй хувийг орон нутгаас авч ажиллуулснаар хүн амын шилжилт хөдөлгөөн багасах, ядуурлыг бууруулах, орон нутгийн хөгжил, эдийн засгийн чадавх дээшлэх, татварын эх үүсвэр болох, эерэг нөлөөлөл их байна.

“Эс Жи групп” ХХК нь “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг MV-021083 тоот тусгай зөвшөөрөл бүхий алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах зайлшгүй шаардлагатай тул 2021 онд хэрэгжүүлэн ажиллах БОМТ-г боловсруулаа.

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

1.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага

2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Цагаан-Овоот уул ” нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг нь уг төсөл хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК-д тавигдаж байна.

Иймд шинэчлэн баталсан хуулийн дагуу “Цагаан-Овоот уул ” нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад баримтлах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батлан мөрдүүлнэ.

Шинэчлэн батлагдсан хуульд Байгаль орчин, Аялал жуулчлалын яам /БОАЖЯ/ тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт нэлээд тодорхой болох ач холбогдолтой юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулсан.

Нөгөө талаас “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эс Жи групп” ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Гэхдээ БОАЖЯ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон тус хуулийн 9.12-т зааснаар хянуулсан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд уг дүгнэлт төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үндэслэн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ тухайн хуулийн 9.15-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын дагуу шийдвэрлэх юм.

“Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага бас тавигдсан.

1.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, Аялал

жуулчлалын яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлсон. Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай зэрэг хуулиуд түүнтэй холбогдох бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргүүдийг тусгасан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд;

- Монгол улсын БОНХАЖЯ- наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг аль болохоор хангасан байх;
- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон, удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор

бууруулж, байгаль орчныг хамгаалж байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах зорилтыг хангах үүднээс үүнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;

- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөж явуулахад лавлах баримт бичиг болох;


Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлэн явуулахын тулд байгаль орчны параметрууд тус бүрд сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөгөөт ажил, төслийн ойр орчмын байгалийг хамгаалах талаар гүйцэтгэх ажлуудыг уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Иймд менежментийн төлөвлөгөө нь энэ төслийн салшгүй нэг хэсэг төдийгүй түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь болж өгнө.

ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн товч танилцуулга

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1663 км, Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос баруун зүгт 55-60 км, Цэнгэл сумын төвөөс зүүн хойд зүгт 7 км, Улаанхус сумаас баруун тийш 30 км зайд, Ховд голын Хар салааны бэлчир нэртэй газарт, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн M-45-107 хавтгайд 1802.56 гектар талбайг эзлэн оршино.



Зураг 1.Төслийн талбайн сансрын зураг

Төсөл хэрэгжүүлэгч	“Эс Жи групп” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011008070, Регистрийн дугаар: 2621169
Төслийн нэр	“Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн орд
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	801, Эм Эс Эн Бьюлдинг, Махатма Ганди гудамж, 15-р хороо, Хан- Уул дүүрэг, Улаанбаатар- 17010, Монгол Улс, Утас/ Факс: 8313-8807
Төслийн зорилго	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол

	улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.
Тусгай зөвшөөрлийн дугаар	“Эс Жи групп” ХХК-нь MV-021083 дугаар бүхий 2003.63 га талбайг ашиглах ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгөөр Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна.

"Эс Жи групп" ХХК нь ажлын туршлага боловсон хүчин, техник, технологийн материаллаг бааздаа тулгуурлан Цагаан-Овоот уул алтны үндсэн ордыг ашиглаж, хаалтын жилд нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгнө.

Ашиглах хугацаа

Төлөвлөгөөнд 3 жил ашиглана гэж заасан боловч цар тахал ба өндөр хүчдэлийн цахилгаантай холбох барилгын болон засварын ажил нь бүрэн дуусаагүй учраас тодорхой хугацаа заах боломжгүй ба хууль дүрмийн дагуу үйл ажиллагааг явуулах болно.

Далд уурхайн ажиллах горим

Далд уурхайн ажиллах горим нь жилд 330 хоног тасралтгүй олборлолтын ажил явуулан хоногт 3 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг, ээлжийн цаг ашиглалт 76% байна.

2.2 Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал

Физик газарзүйн нөхцөл

“Цагаан-Овоот уул” алтны үндсэн орд нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт нийт 1802.56 га талбайг хамран оршдог. Төслийн талбай нь Цэнгэл сумын төвөөс зүүн хойш 10-15 км, Ховд голын Хар салааны бэлчир нэртэй газарт оршдог.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эс Жи групп” ХХК нь Монгол улсын аж ахуйн нэгжийн бүртгэлд гадаад худалдаа, ашигт малтмал ашиглалт чиглэлээр 2005 оны 11 сарын 10-нд бүртгүүлэн Монгол Улсын бүртгэлийн 9011008070 тоот гэрчилгээ авсан.

Уур амьсгал

Баян-Өлгий аймгийн нутаг нь далайн түвшнээс дээш 1350-4374 метр өргөгдсөн, өндөр уулсаар хүрээлэгдсэн учир эх газрын эрс тэс уур амьсгалтай, урт удаан үргэлжилсэн өвөлтэй, богинохон сэрүүн зунтай. Тухайлбал өвөлдөө -25-35°C, зундаа +25-аас +35°C, жилийн дундаж хур тунадас 110-130 мм түүнээс бага, агаарын чийгшил 20-25 % байдаг. Баруун хойноос чиглэлтэй 9-16 м/сек, хүчтэй салхи салхилдаг. Өвөлдөө уулархаг нутгаар цасан бүрхүүл 0.3-0.4 м зузаантай, талархаг гадаргуудаа зарим жилд 0.1 м хүртэл бага зузаантай цасан бүрхэвч тогтдог. Тус сумын нутагт мөнх цаст, өндөр уул нуруунууд элбэг байдаг учраас өвөл урт үргэлжилдэг, хахир хүйтэн байдаг. Хамгийн хүйтэн өдөр нь 40°C-аас дээш байдаг ба хамгийн халуун өдөр 30°C. Агаарын температурын дундаж -40с, -80с. Жилийн 230-250 хоног нь цэлмэг, өвлийн улирал нь урт байдаг байна.

Агаарын чанар

Төсөл хэрэгжих талбайд одоогийн байдлаар үйдвэр бүрэн үйл ажиллагаагаа эхлээгүй учраас агаарын орчинд бохирдол үүсээгүй ба төлөвлөгөөнд тусгасаны дагуу биологийн нөхөн сэргээлтүүд хийж байгаа.

Физик бохирдол, хог хаягдал

“Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордын төсөл хэрэгжих талбайд ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй байгаа бөгөөд өнөөгийн байдлаар төслийн талбайд физик бохирдол болон хог хаягдлын бохирдол үүсээгүй байна.

Геологийн тогтоц ба геоморфологи

Төслийн талбай нь Монгол Алтайн металлогений мужийн Алтай ба Дэлүүн-Юостьцын металлогенийн бүсийн (С.Дандар, Г.Дэжидмаа нар 2001 он) зангилаа хэсэгт оршдог.

Цэнгэл хайрханы хүдрийн зангилаа нь М-45-107-В,Г листүүдэд Хатуугийн (12) хагарал орчимд Цагаан овоотын (13) хагарлаас баруун тийш Цагаан голын адаг орчимд байрлана. Энэ зангилаанд цаашид нарийвчилсан эрлийн ажил хийх шаардлагатай 284 км² хэмжээтэй Хатуу уулын алт-зэсийн хүдрийн В зэрэглэлийн талбайг (В-2) ялгасан байдаг. Уг талбайд Цагаан овоот уулын алт-зэсийн илрэлийн талбай болон зэсийн 9.5, алт-зэсийн 3,6 дугаартай эрдэсжсэн цэгүүд, мөн зэсийн 4, титаны 1 ш цэгэн гажлууд хамрагддаг.

Ургамлан нөмрөг

Ургамалжилтын бүлгэмдлийн хувьд Монгол-Алтайн чулуурхаг хөрстэй өндөр уулын хээрийн (1600-2800 м) Алаг өвс-жижиг дэгнүүлт үетэнт бэлчээр, Монгол өвс-Харганат (1955 м) бүлгэмдлүүд тархсан байна. Төсөл хэрэгжих талбай болон түүний ойр орчимд хийсэн ургамлын аймгийн судалгааны явцад нэн ховор, ховор статустай ургамал бүртгэгдээгүй боловч бэлчээр, тэжээлийн үнэт ургамал Сайрын хялгана (*Stipa glareosa*), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica*), *Гялгар дэрс* (*Achnatherum splendens*) тохиолдсон.

Амьтны аймаг

Алтайн бүс нутаг нь ой мод, гол горхи, нуур цөөрөм ихтэй, үржил шим бүхий экосистем учир тус нутагт ан амьтан, жигүүртэн шувууд элбэг байдаг. Сыргалын хөндий, ойн чөлөө, уулын энгэрт баавгай, буга, гөрөөс, асга хад эгц цавчим уулын энгэрт аргал угалз, янгир ямаа идээшин нутаглана. Ирвэс, шилүүс, чоно, үнэг, хярс, нохой зээх, мануул, өмхий хүрэн, цагаан үен, тарвага, зурам, хэрэм, туулай мэтийн амьтадтай хаа сайгүй тааралдаж болно. Харин ховордсон булга, суусар зэрэг амьтад хаа нэгтээ үзэгдэнэ.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээнээс дүгнэн уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг доор авч үзлээ.

- Уурхайн бүтээн байгуулалт, олборлолт, үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 14.57 га талбай эвдрэлд өртөх
- Баяжуулах үйлдвэрийн хаягдал, хаягдлын сангаас бохирдол үүсэх
- Хүнд оврын машин механизмын авто зам, бусад үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг доройтох, хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орох

Иймд Цагаан-Овоот уул нэртэй алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн БОНБНУ-ний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж хэсэг мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг мөрдөж ажилласнаар уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байдлаар явуулах бүрэн боломжтой. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл, өртөх орчин, нөлөөллийн эрчим

Уурхайн олборлолтоос үүсэж болзошгүй гол сөрөг нөлөөллийг Лиополдын матрицын хүснэгтийн аргаар үнэлсэн бөгөөд нөлөөлийн хэмжээг 1-10 баллаар үнэлэн /1 нөлөөлөл хамгийн бага байх утга 10 нөлөөлөл хамгийн их утга/ төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг нийт үзүүлэлтүүдийн дундажтай харьцуулан гаргасан.

Хүснэгт 2. Нөлөөллийн эрчим

Сөрөг нөлөөллийн эрчим	Нөлөөлөл дунд зэрэг /4-6 балл/	Нөлөөлөл бага /1-3 балл/
Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Уурхайн олборлолт	Уурхайн хог хаягдал хаях цэг, эрүүл ахуйн бүс Хүнд оврын машин механизмын засвар үйлчилгээ, засвар механикын цех Уурхайн хотхон
	Уурхайн дотоод тээвэр	Уурхайн гадаад, дотоод овоолго үүсгэх үйл ажиллагаа

Сөрөг нөлөөлөл дунд /4-6 балл/: Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлий, гадаргын болон гүний усны бохирдол үүсгэх агаарын чанарт нөлөөлөх, уурхайн тээврийн зам дагуух хөрсөн бүрхэвч элэгдэлд орох, хур тунадас багатай байгаагаас тоосжилт ихээр үүсэх, хаягдлын далан орчимд гадна хашлага хаалт хийгээгүйгээс мал амьтан унаж үрэгдэх, уурхайн далд амны орчимд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, хөрсний нуралт гулсалт үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Сөрөг нөлөөлөл бага /1-3 балл/: Хог хаягдал хаях цэг, орчны эрүүл ахуйн бүс, машин техникийн засвар үйлчилгээний цэг, шатах тослох материал хөрсөнд нэвчих, шимт хөрсний гадаад дотоод овоолгоос эрүүл газар доройтох, нөхөн сэргээлтийг аргачлалын дагуу хийгээгүйгээс бэлчээр нутаг хумигдах цаашлаад тухайн орчинд экосистемийн доройтол үүсэж болзошгүй байна.

ДӨРӨВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/				Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Агаарын чанар									
1	Далд уурхайн үйл ажиллагааны үед тоосжилт үүсэх	Далд уурхайд ажиллаж буй хүмүүс тоосжилтоос хамгаалах маск олгох	Далд уурхайн хэсгийн ажилчид			--	Төслийн ХАБ-ын зардалд тусгагдсан	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл
2		Тээврийн хэрэгслийн зорчиж буй замыг сэргээн засах, шаардалгатай бол дулааны улиралд услах	Төслийн талбай			--	БОМТ-тусгасан төсвөөр	2023	
3	Баяжуулах үйлдвэр, хаягдлын далангаас тоосжилт үүсэх	Далд уурхайгаас ирсэн хүдрийг бутлах үед тоосжилт үүсэх тул баяжуулах үйлдвэр, тээрмийн гэжээгүүр дээр вентиляторуудыг тогтмол ажлуулах	Баяжуулах үйлдвэрийн ажилчид			--	Анхны хөрөнгө оруулалтын зардалд тусгагдсан	2023	
4	Уурхайн хотхон, зам талбайн бүрэн бус байдлаас үүсэх тоосжилт	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор мод “Тэрбум мод”, сөөг тарих	Төслийн талбай				10.000.0	2023	

5	Машин, тоног төхөөрөмжийн бүрэн бус байдлаас үүсэх утаа	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хугацаанд хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг MNS 5014:2009 стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах	Ашиглагдаж буй бүх тээврийн хэрэгсэл				--	Уурхайн урсгал зардалд тусгагдсан	2023	тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
7	Хоосон чулуу хүдрийн овоолго	Хоосон чулуулаг, хүдрийн овоолгийн талбайг ТЭЗҮ, УАТ-нд тусгасаны дагуу төлөвлөх, хамгийн бага талбайд овоолго хийхээр төлөвлөх	Төслийн хүрээнд				--	--	2023	
2. Гадаргын ба газрын доорх усны нөөц										
1	Унд болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглан усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулж, усны нөөц, чанарыг хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу тайлан гаргаж тухай бүрт арга хэмжээ төлөвлөн гүйцэтгэх	Үйлдвэрийн талбайн хэмжээнд				--	--	2023	Усны тухай хуулийн 28-р зүйл Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд
2		Зам усалгааны машин	Төслийн хүрээнд					Компанийн өөрийн эзэмшилд байгаа	2023	

3		Усны зөв зохистой хэрэглээг хангаж ажиллах, усны хэрэглээнд хяналт тавих, тоолууржуулах	Үйлдвэрийн ажилчид			2ш	Компанийн өөрийн эзэмшилд байгаа	2023	зарцуулах усны норм А-301 тушаал, Байгаль орчны хохирлын үнэлгээ нөхөн төлбөр тооцох аргачлал
4	Унд болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглан усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Үйлдвэрт усыг дахин ашиглахдаа технологийн горимыг алдагдуулахгүйгээр ашиглах	Үйлдвэрийн хэрэглээнд ашиглагдах ус			--	Үйлдвэрт ашиглагдах усны 93.%-ийг эргэлтийн усаар хангахаар төлөвлөсөн	2023	
5		Ахуйн хэрэгцээнд усыг ашиглахдаа орчин үеийн ус бага хэрэглэх тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг сонгон авах	Төслийн хүрээнд			--	--	2023	
6		Ахуйн хэрэглээнээс гарах саарал усыг дахин ашиглах	Төслийн хүрээнд				--	2023	
7		Мониторингийн цооногийн усны түвшинг тогтмол хэмжих	Төслийн хүрээнд				--	2023	

3. Хөрсөн бүрхэвч

1	Уурхайн бэлтгэл ажлын үед хөрсөн орчинд сөрөг нөлөөлөл үүсэх	Замын нэгдсэн маршрут гаргаж ажлын явцад ашиглах зам талбайг заасаж сэргээх , Бэлтгэсэн талбайгаас бусад замаар зорчихгүй байх, хаалт хашилт тэмдэгжүүлэлтийн хянах сэргээн засах жил бүр	Төслийн талбай	Замын тэмдэглэгээний тоо			1.000.0	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл Үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
2		Далд уурхайгаас гарсан хоосон чулуулгийг зам талбайг бэлтгэхэд ашиглаж, зам хийх, карьер хийхээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбай				--	2023	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
3	Уурхайн үйл ажиллагааны явцад хөрсөн орчинд сөрөг нөлөөлөл үүсэх	Шатах тослох материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлж агуулах засварын талбайн шалыг цементлэх, /Машин механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр талбайд хийж гүйцэтгэх/	Төслийн талбайд				Анхны хөрөнгө оруулалтын зардалд тусгагдсан	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл Үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
4		Хаягдлын далангийн үер ус зайлуулах суваг шуудуу, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, сэргээн засах ажлыг жил бүр зохион байгуулах	Төслийн талбайд		300.0	1 жил	300.0	2023	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008

4. Газрын хэвлий

1	Далд уурхай, овоолго болон уурхайн үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглах	Төслийн хүрээнд					--	2023	Газрын хэвлийн тухай хууль 31-р зүйлийн 1 дэх заалт
2		Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүнд ИТА-д хяналт тавих, хариуцан ажиллах	Төслийн хүрээнд					--	2023	Газрын хэвлийн тухай хууль 32-р зүйлийн 8 дахь заалт
5. Ургамлан нөмрөг										
1	Ургамлан нөмрөгийг доройтуулснаар амьтдын идэш тэжээлийн хомсдол үүсэх, бэлчээр доройтох	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах, ургамлан нөмрөгийг талхлагдахаас сэргийлэн уурхайн кемп орчимд хамгаалалтын бүс тогтоож хашаалсан хэсэгт тарисан модыг хамгаалаж уурхайн орчинд тарих боломжтой ургамал тарих	Төслийн хүрээнд					300.0	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл, Ургамал хамгааллын тухай хууль
4		Уурхай орчмын ургамлын судалгааг хийж бүртгэлжүүлэх	Төслийн талбайд					--	2023	Байгалийн ургамлын тухай хууль 7 дугаар зүйл
6. Амьтны аймаг										
1	Уурхайн бэлтгэл ажлын үед амьтдын	Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй,	Уурхайн ойр орчимд	Замын тэмдэглэгээ	20.0	10ш		200.0	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл,

	Үүр, идэш тэжээлд сөрөг нөлөөлөл үзүүлэх	нүх оромжийг анхааруулсан тэмдэгүүд байрлуулах							Амьтны тухай хууль 6 зүйл
2	Өрөмдлөг тэсэлгээ тээврийн хэрэгслийн	Хайгуул, олборлолтын үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Уурхайн ойр орчимд					2023	
3	хөдөлгөөнөөс тухайн орчинд амьдарч байсан амьтад дайжих	Төслийн талбайн ойр орчмын модонд шувуудын үүр барих, цахилгааны шон дээр шувуу үргээх хэрэгслүүдийг хянаж тогтмол байршуулах (mirror, brush, pipe, plastic sheet)	Уурхайн ойр орчимд				200.0	2023	
4	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын даланд тэжээвэр мал амьтад орох	Мал амьтад орохоос сэргийлэн хашаа хаалтыг сайжруулах бүтэн байдлыг тогтмол хянаж ажиллах	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын далан				1.500.0	2023	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал							13.500.0		

4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/				Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
2023 онд Нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй. Шимт хөрсийг овоолох, хадгалах ажлын зардлыг сөрөг нөлөөллийг буруулах хэсэгт тусгав.								

4.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
Дүйцүүлэн хамгаалах, бэлчээрт олон наст ургамал тариалах ажлын зардал								
1	Цэнгэл сумд Хамтаран ажиллах гэрээнд тусгасаны дагуу мод тарих талбайг бэлгэж өгнө		Цэнгэл сум			50.000.0	2023	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага БОНБНУ-ий тухай хуулийн 3.1.11, 8.4.6, 9.6 зүйл, Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
“Алтай таван богд” БЦГ-т дүйцүүлэн хамгаалах ажлын зардал								
1								
2		“Алтай таван богд” БЦГ-ын хамтын ажлын гэрээнд тусгасан угтах хаалгыг янзалж өгөх	“Алтай таван богд” БЦГ			1.000.0	2023	БОНХ-ийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан БОНБНУ-ний аргачлалын 3.3.6
Багийн иргэдийн нийтийн хурлын санал болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлагыг үндэсэн тусгав.								
Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал						51 000.0		

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1	Төслийн кадастрын зураг, хээрийн судалгааны явцад тус төслийн талбайд нүүлгэх 6 айл байгаа бөгөөд эдгээр айлыг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай тохиолдолд бэлчээрийн нөхөн олговор олгох		Нүүлгэн шилжүүлэх айл				2023	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал 4.3.5
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олох арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал								

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Археологийн дурсгал								
1	Төслийн талбайн хамрах хүрээнд нийт 27 археологийн дурсгал байгаа бөгөөд эдгээрээс 11 дурсгал нь тус талбайн зүүн хойд болон баруун урд хэсэгт байрлаж, бусад 16 дурсгал нь талбайн гадна баруун урд талд 10-250 метрийн зайд тус тус оршиж байна. Нийт 27 дурсгалаас хиргисүүр 11, чулуун байгууламж 8, булш 7, хөшөө чулуу 1 байна.	Төслийн талбайд өрөмдлөг хийх, хөрс хуулах ашиглалтын бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд илэрсэн дурсгалуудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дурсгалуудыг малтан судлуулж талбайг чөлөөлүүлэх, түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх, газар хөндөх ажилд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулна.	Төслийн талбайд илэрсэн археологийн дурсгалууд	1	1	2 000.0	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31-р зүйл, Соёлын өвийг хамгаалах тухай хууль 27 зүйлийн 8,9,10 дэх заалт

2. Палеонтологийн дурсгал

1	Төслийн хамрах хүрээнд палеонтологийн дурсгал илрээгүй байна. Хэрэв цаашид төслийн хэрэгжилтийн явцад төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн палеонтологийн олдвор олоход үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА, Палеонтологийн хүрээлэн 70118283, Түүх угсаатны зүйн хүрээлэн 11-458305-д нэн даруй мэдэгдэж арга хэмжээ авах шаардлагатай.	
Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал		2 000.0

4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал			
1. Гэнэтийн осол аваар									
	Ажлын байранд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслэлээр бүрэн хангах	Бүх ажилчид			--	2023	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас-ерөнхий шаардлага MNS ISO 13688:200	
		ХАБЭА-н дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, галын аюулаас хамгаалах, төлөвлөгөөг ажилчдад танилцуулж, ажил эхлэхээс өмнө аюулгүй ажлын зааварчилгаатай танилцуулах	Бүх ажилчид	500.0	1жил	500.0	2023		
		Ажилчин бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, дохиолол, холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалгах	Бүх ажилчид				--		2023
		Эмнэлгийн анхан шатны тусламжын хайрцагт байх эм, хэрэгсэл материалуудаар хангах	Бүх ажилчид				5.000.0		2023
		Ажлын байртай танилцах АА дүрмийн сургалт				Сар бүр			2023

2.Байгалийн гамшигт үзэгдэл								
	Үер усны аюул	Гэнэтийн үер усны аюулаас урьдчилан сэргийж үерийн даланг жил болгон сэргээн заасах				--	2023	Галын аюулгүй байдлын тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал						5.500.0		

4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Ахуйн хог хаягдал								
1	Цаасны хаягдал	Оффисоос гарч буй цаасны хаягдлыг (бүх төрлийн цаасан хайрцаг, ногоогүй шохойгүй хоол хүнсний бохирдолгүй байх) зориулалтын хогны уутанд ангилан хаях	Төслийн үйл ажиллагааны хүрээнд			--	2023	Хог хаягдлын тухай хууль 10 зүйл
2	Хүнсний хаягдал	Уурхайн кемп гал тогооноос үүсч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн кемп			--	2023	
3	Хуванцар хаягдал	Уурхайн кемпээс үүсэж болох хуванцар сав баглаа боодлыг (цэвэр ус, ундаа, хоолны хуванцар сав ундааны лааз, тугалган сав гэх мэт) савыг суллан зориулалтын газарт цуглуулж эргүүлэн ашиглах шаардлагатай газарт нь өгөх	Төслийн талбай			--	2023	
4	Бусад	Хатуу хог хаягдлыг хөрсөнд элдэв шингэн нэвчиж бохирдуулахааргүй, салхинд хийсч орчныг бохирдуулахааргүй тусгайлсан төмөр торон хашлагад байршуулах, хатуу хаягдал цуглуулах байгууламж хийх	Төслийн талбай			Төмөр торон хаягдал цуглуулах сав 40x40 өндөр нь 10м геомембран аар доторлож	2023	

						20-30см элс хайрга дэвсэх 1.000.0		
5		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах (ажилчдын байрны ойролцоо болон дотор орчинд)	Төслийн талбай		20ш	400.0	2023	
6		Дахин боловсруулагдахгүй бусад хаягдлыг (хоолны хаягдал, норсон, дахин ашиглах боломжгүй хаягдал, 00-н цаас) зориулалтын хогийн цэгт хаях	Төслийн талбай			--	2023	
2. Үйлдвэрийн хог хаягдал								
1	Төмрийн хаягдал	Төмрийн хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх	Төслийн талбай			--	2023	Хог хаягдлын тухай хууль 10-р зүйл
2	Модны хаягдал	Модны хаягдлыг ахуйн түлшинд хэрэглэх	Төслийн талбай			--	2023	
3. Аюултай хог хаягдал								
1	Аюултай хог хаягдал	Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт (Алтан оршихуй ХХК, 99104569) хүргүүлэх, гэрээ хийн хамтран ажиллах	Төслийн талбай			--	2023	Хог хаягдлын тухай хууль 5-р бүлэг
2		Аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг (гутал, химийн бодист тэсвэртэй хамгаалалтын хувцас,	Төслийн талбай				--	

		малгай, нүдний шил, бээлий, нүүрний баг, амьсгал хамгаалах баг) шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангах						
3	Бусад	Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт цуглуулан тээвэрлэхдээ сумын захиргаатай гэрээ байгуулж ажиллах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд		1 удаа		2023	
4		Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	Төслийн талбай	100.0	Жилд 8 удаа	800.0	2023	
5		Нийтийн цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа зохион байгуулах	Төслийн талбай	--	Сард 2 удаа	--	2023	
6		Химийн бодисын хаягдлыг сумын байгаль орчны байцаагч мэдэгдэж , уурхайн химийн бодисын асуудал хариуцсан ажилтнуудыг байлцуулан гэрээний дагуу усатгалд оруулах ба ачуулах	Агуулах лабораторид ажиллаж байгаа ажилчид	500.0	Жилд 2 удаа	100.0	2023	
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал						2.300.0		

4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Цагаан-Овоот уул алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК-д зүй ёсоор тавигдаж байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон Цагаан-Овоот уул алтны үндсэн орлыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад “Эс Жи групп” ХХК-аас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дэвсгэрт бий болсон болон болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр Алтны үндсэн ордын талбайн төслийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарах болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

ОХШХ-ий хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй Цэнгэл сумын нөлөөллийн бүс түүний орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах, сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай. Хагас жил бүр орчны хяналт, шинжилгээний үзүүлэлтийг анхааралтай судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй, тодорхой болгоход ашиглах шаардлагатай.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭС ЖИ ГРУПП” ХХК-ИЙН MV-021083 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “ЦАГААН ОВООТ УУЛ” НЭРТЭЙ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
				Нэгжийн зардал	Давтамжийн тоо	Нийт зардал		
1. Агаар орчин								
1	Агаар орчны шинжилгээг мэргэжлийн байгууллага шинжээчээр хийлгэх	Төслийн талбай	Жилд 2 удаа /5 цэгээс нөлөөллийн бүс болон нөлөөллөөс гаднах талбайд			100.0	Мэргэжлийн экспертийн нэг удаагийн судалгаа хийх	Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063:2010 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
2	Гадаад болон дотоод орчны дуу чимээний түвшин Тоосжилт (PM2.5, PM10) Агаар бохирдуулагч бодисын хэм хэмжээ CO, SO ₂ , NO ₂	Уурхайн карьер, тээврийн зам, ажилчдын тосгон	(PM2.5, PM10) жилд 2 удаа, CO, SO ₂ , NO ₂ өдөр бүр			100.0	Мэргэжлийн экспертийн нэг удаагийн судалгаа хийх	
2. Хөрсөн бүрхэвч								
3	Хөрсний хими физикийн шинж чанар	Шимт хөрсний овоолго, уурхайн карьер, ажилчдын тосгон	Жилд 2 удаа		Жилд 2 удаа	200.0	Хавар, намрын улиралд	Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS 3985-87 Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох MNS 3310-91 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305-94
4	Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд	ШТМ-ын агуулах						

								Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
5	Хөрсөн дахь натрийн цианидыг тодорхойлох шинжилгээ Нийт болон чөлөөт WAD	БО-ны хяналтын 5н цэгээс						
6	Гэнэтийн аюул ослын үед хөрсөнд асгарсан тохиолдолд тухайн бодисын шинжилгээг хийх	Тухайн цэгт						
3. Усан орчин								
5	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага (Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ Катионууд: Na ⁺⁺ K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , рН, ЕС, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)	Унд ахуйн хэрэглээний ус	Жилд 2 удаа	92.0	Жилд 2 удаа	92.0	Жилд 2 удаа	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус ерөнхий шаардлага MNS 4943:2008 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010
6	Усан дахь нян бактерийн шинжилгээ	Усны эх үүсвэр	Жилд 2 удаа	120.0	Жилд 2 удаа	120.0	Унд ахуйд усанд химийн болон бактерлогийн бүрэн	Ундны усны эрүүл ахуйн шаардлага чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭС ЖИ ГРУПП” ХХК-ИЙН MV-021083 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “ЦАГААН ОВООТ УУЛ” НЭРТЭЙ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

							шинжилгээ хийлгэхэд жилд 2 удаа 60.0*2=120.0	
7	Уснаас натрийн цианидыг тодорхойлох шинжилгээ	Эргэлтийн уснаас	Улирал тутам	100.0	Жилд 4 удаа	400.0	Шаардлага гарвал үйлдвэрийн ажиллах оргил цагын үед улиралд 2 удаа шинжилгээ хийнэ	
8	Гэнэтийн аюул ослын үед усанд асгарсан тохиолдолд тухайн бодисын шинжилгээг хийх	Тухайн усан сан (тухайн цэгт)						
4. Ургамлан нөмрөг								
7	Ургамлын зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, арвийн үнэлгээ	Уурхайн талбайн ойр орчмын	Жил бүрийн 7-р сард	500.0	3жил	500.0	Мэргэжлийн экспертийн нэг удаагийн судалгаа хийх хөлс 500.0*1жил	Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 Ургамлын хээрийн судалгааны арга зүй
5. Амьтны аймаг								
8	Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх	Төслийн талбай болон түүний орчимд	Жил бүрийн 7-8-р сард	500.0	3жил	500.0	Мэргэжлийн экспертийн нэг удаагийн судалгаа хийх хөлс 500.0*1жил	Амьтны судалгааны арга зүй
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						2.132.0		

4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнг захирлын тушаалаар томилох, байгаль орчны асуудлыг хариуцан ажиллах	Уурхайн урсгал зардалд тусгагдсан	Удирдлага	
2	Ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулах	--	Геологи инженер	
3	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	--	Байгаль орчны мэргэжилтэн	
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг тухайн жилийн 10 дугаар сарын 31 ны дотор Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэх	--	Байгаль орчны мэргэжилтэн	
5	Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн газрын төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирал бүрийн эхний сарын 20-ны дотор төлөх	--	Удирдлага	
6	“Монгол ус” ТӨААТҮГ-аар ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах, төлбөрийг төлөх	--	Байгаль орчны мэргэжилтэн	
7	Болзошгүй аюул ослын үед ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	1.000.0	ИТА	
8	Өвөлжилт хүндэрсэн үед нутгийн иргэдэд өвс, хадлангийн тусламж үзүүлэх	--	ИТА, ажилчид	
9	БО-г хамгаалах, ХАБЭА, ШТМ-ын асгаралт, хадгалалт, ашиглалт, устгалын чиглэлээр өөрийн	400.0	ИТА	

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭС ЖИ ГРУПП” ХХК-ИЙН MV-021083 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “ЦАГААН ОВООТ УУЛ” НЭРТЭЙ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	ажилтан, ажилчдын дунд улирал тутамд сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, Өдөр тутамд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх			
10	Байгаль орчныг хамгаалах мэдээ мэдээлэл, сурталчилгааны самбар хийж байнгын цахим мэдээллээр хангах	500.0	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА	
11	Орон нутгийн удирдлага болон иргэдэд төслийн үйл ажиллагааны биелэлт, байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар танилцуулга, хэлэлцүүлгийг тогтмолт хийж байх	--	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА	
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал	1800.0		

4.11 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
	Цэнгэл сумын ИНХ	Сумын ИНХ-аар илтгэл тавьж, мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Жилд 1 удаа	500.0	ИТА, Байгаль орчны мэргэжилтэн	Цэнгэл сумын ИНХ
	Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	БОМТ биелэлтийн тайланг тайлан хэлбэрээр хүргүүлэх, биелэлтийн тайлан дүгнэх ажлын хэсгийн хамт газар дээр нь танилцуулах	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	Жилд 1 удаа	500.0	ИТА, Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
	БОАЖЯ	БО-г хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөө БОАЖЯ – нд цаг тухайд нь гаргаж өгч байх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөө	Жилд 1 удаа	500.0	ИТА, Байгаль орчны мэргэжилтэн	БОАЖЯ
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний нийт зардал					1500.0		

2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Менежментийн төлөвлөгөө	Нийт дүн /мян.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13.500.0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	51.000.0
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	2 000.0
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5 500.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 300.0
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	2 132.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 800.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1 500.0
Нийт зардал	79.732.000

Эс Жи групп ХХК-ийн Цагаан-Овоот уул нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн 2023-оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнд нийт **79 732 000** төгрөг зарцуулахаар тусгалаа.

ДҮГНЭЛТ

“Эс Жи групп” ХХК-ийн “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөж 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсрууллаа.

“Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордын MV-021083 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай нь нийт 1802.56 гектар талбайг бөгөөд алтны үндсэн ордыг ашиглах энэхүү төсөл хэрэгжсэнээр нийт 186 хүний ажлын байр шинээр бий болж байна.

Төслийн бүтээн байгуулалтын буюу 2023 онд далд уурхай тул байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь уурхайн олборлолт болон түүхий эдийн тээвэрлэлт, ачиж буулгах үйл явцаас үүсэхээр байна.

Иймээс төслийн бүтээн байгуулалт, олборлолт, үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, ажлын хүрээнд удирдлага, зохион байгуулалтын зүгээс авах арга хэмжээ, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрын дагуу хийж гүйцэтгэх арга хэмжээг тус тус төлөвлөсөн. 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн ажлын хүрээнд байгаль орчны аудит болон төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө газрын төлөв байдал чанарын хянан баталгааг хийлгэх зайлшгүй шаардлагатай.

Алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **79 732 000** төгрөг, үнээс Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт 2 132 000 төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөсөн.

“Цагаан-Овоот уул ” нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг нь уг төсөл хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК-д тавигдаж байна.